

МУИС-ийн “Геологийн асуудлууд” сэтгүүлийг Монгол Улсад Геологийн мэрэгжилтэй боловсон хүчин бэлтгэж эхэлсэний 50 жилийн ойд зориулан тусгай дугаар гаргах гэж байгаа тул Эрхэм хүндэт .....та бүтээлээ нийтлүүлнэ үү?

“Геологийн асуудлууд” сэтгүүлд хэвлэгдэх өгүүлэлд тавигдах шаардлага.

1. Өгүүлэл нь холбогдох зураг, схем, хүснэгтийн хамт 10-20 нүүр; товч мэдээлэл 3 хүртэл нүүрээс илүүгүй байх.
2. Өгүүлэлийн сэдвийн нэрийг Times New Roman-12 (том үсгээр), Зохиогчийн нэрийг Times New Roman-8 (том үсгээр), ажлын газрын хаягийг Times New Roman-8 (жижиг үсгээр), товчлол Times New Roman-9, бичлэгийг Times New Roman-10 хэмжээгээр бичнэ. Мөр хоорондын зай 1,3. Схем, зургийн тайлбар, хүснэгтийн бичвэрийг мөн фонтын 8-р бичнэ. Харин хүснэгт схемийн гарчигийг 8(bold)-р бичнэ.

Жишээ нь:

АР НАЙМГАНЫ АЛТНЫ ОРДОД БАГЦ АРГААР БҮЛЭГ ЦООНОГ  
ӨРӨМДСӨН ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮН

С.В.ПАУШОК,<sup>1</sup>Н.Я.БАБКИН,<sup>1</sup>В.Г.ЖУРАВЛЕВ,<sup>1</sup>  
С.С.КОЗЛОВСКИЙ,<sup>1</sup>С.ЦЭРЭНОЧИР<sup>2</sup>

<sup>1</sup>Алтан Дорнод-Монгол ХХК<sup>1</sup>  
<sup>2</sup>“Тосон-Алт” ХХК<sup>2</sup>

Түлхүүр үг:

3. Өгүүлэлийг хэвлэсэн эх байдлаар болон файлын хамт редакцын зөвлөлд ирүүлнэ.
4. Редакцад ирүүлсэн өгүүлэлийн эх дээр зохиогчид гарын үсгээ зурж баталгаажуулсан байна.
5. Зураг, график, схем, диаграм зэрэг үзүүлбэр тус бүрийг нэг хуудсан дээр тод үзэмжтэй хэвлэсэн эхээр нь хавсаргана. Үзүүлбэр, зураг, диаграммыг дангаар нь харахад агуулга нь ойлгогдохоор нэр, тайлбартай байх ёстой.
6. Өгүүлэлийн сэдвийг нийтэд нь том үсгээр бичнэ.
7. Сэдвийн доор зохиогчийн нэр, ажилладаг газрын хаяг бичигдэнэ. Олон зохиогчтой тохиолдолд нэр бүрийг ромбо тоогоор ажилладаг газрын нэрийг бичнэ.
8. Товчлолын дор бүтээлийн гол санааг илэрхийлэх 5-аас доошгүй түлхүүр үг эсвэл товч ойлголтыг оруулна.
9. Ишлэл ба ашигласан бүтээлийн жагсаалтыг зохиогчийн нэр, бүтээл хэвлэгдсэн он, бүтээлийн нэр гэсэн дараалалтай бичнэ. Бичвэр дотор хийх дараалалыг доорхи байдлаар бичинэ. Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг, нийтэлсэн он,

зохиолын нэр, хот, хэвлэлийн газар, хуудасыг бичнэ. Жишээлбэл:

1. *Макарычев Г.М., Гесь М.Д., Морковкина В.Ф., Палей И.П. 1990.* Эволюция структуры земной коры докембрий Западной Монголии // В сбор: Эволюция геологических процессов и металлогения Монголии. Москва, Наука. С.81-110

Энэхүү тусгай дугаарын материалыг энэ 2010 оны 8-9-р сард доорхи хаягаар хүлээн авах болно.

МУИС. Газарзүй-геологийн факультет.

Геологи-минералогийн тэнхим.

Өрөө 120 тоот.

Утас:318640, 88005121